

Өөр албан тушаалын үүргийг түр гүйцэтгэж буй алба хаагчдын цалин хөлс нь энэхүү түр хэрэгжүүлж буй албан тушаалын цалин хөлсөөр гэхдээ үндсэн албан тушаалын цалин болон нэмэлт хөлснүүдийг харгалзан түүнээс багагүй хэмжээгээр бодогддог.

Эндээс үзвэл ОХУ-ын ял эдлүүлэх системийн алба хаагчдын цалин хөлс нь тэгшитгэсэн хэлбэрээр бус ялгавартай, өөрөөр хэлбэл тэдний гүйцэтгэж буй ажил үүрэг, түүнийг биелүүлж буй газар, нөхцөл байдал, мэргэжлийн бэлтгэл зэрэг олон хүчин зүйлстэй уялдан хувь хүнд хандсан механизмаар тооцон олгогддог байна.



Л.АЛТАНСҮХ

Хууль сахиулахын их сургуулийн Удирдлагын сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор багш

ХОРИХ АНГИД ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДЛУУД

Хорих анги, цагдан хорих байр нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоонд онцлох байр суурь эзэлдэг. Энэ нь гэмт хэрэг үйлдэгсдэд Монгол улсын Эрүүгийн хуульд заасан ял оногдуулахад эзлэх хорих ялын хувийн жин төдийлөн буурахгүй байна.

Өнөөдрийн байдлаар Монгол улсад нийт 42 хорих анги, цагдан хорих болон баривчлах байр байгаагаас төвлөрсөн хорих анги 25, баривчлах цагдан хорих байр 26 байна.

- гяндан 1,
- Онцгой 1,
- Чанга дэглэмтэй хорих 11,
- Жирийн дэглэмтэй хорих 12,
- Баривчлах ял эдлүүлэх анги 1,
- Баривчлах ял эдлүүлэх байр 13,
- Цагдан хорих байр 25 байгаа ба

тэдгээрт нийт 7000 гаруй ялтан ял эдлэж, 1300 орчим хоригдогч цагдан хоригдож байна.

Хорих анги, цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах, хоригдогч этгээд, ялтнаас нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг биелүүлэх нэг чухал нөхцөл бол

ШШГБ дах хяналт, харуул хамгаалалт юм. Хорих анги, цагдан хорих байрны хяналт, харуул хамгаалалтын байдлыг ШШГТМУХ, СЯБЦХШБТМУХ болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан заавар журамд заасны дагуу нарийн чанд зохион байгуулах нь тухайн хорих анги, албаны удирдлага, албан хаагчдын төрийн өмнө хүлээсэн онцгой үүрэг байдаг.

Хоригдогч этгээд, ялтны оргох болон бусад төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорих анги, албаны хэвийн үйл ажиллагааг хангах, хоригдогч этгээд, ялтны зүгээс учруулж болох гэмт халдлагаас иргэн нийгмийг хамгаалах, ялын зорилгыг хангахын тулд тэднийг байнгын хяналт хамгаалалтанд байлгах замаар хорих ял эдлэж байх хугацаандаа аливаа эрх зүйн зөрчил, гэмт хэрэг үйлдэхэд хүргэж болох шалтгаан нөхцөлийг судлан тогтоож, тийм боломжийг бүх талаар гаргахгүй байхтай холбогдсон зохион байгуулалтын иж бүрэн арга хэмжээг хуулийн дагуу авч хэрэгжүүлэх ёстой болдог.

Хорих ангид хоригдогч этгээд, ялтан оргох, амиа хорлох, бусдыг барьцаанд авах, бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулах, хорих ангийн дотоод журмыг удаа дараа зөрчих, эмх замбараагүй байдал үүсгэх, албан хаагчын тавьсан шаардлагыг эсэргүүцэж бусдыг уриалан дуудах, албан хаагчын амь биед халдах явдал үйлдэгдэж буй нөхцөлийг товч байдлаар тодорхойлбол энэхүү сөрөг үзэгдлийн шалтгааныг нөхцөлдүүлж буй нийгмийн болон ахуйн орчин нөхцөл юм.

Шинээр цагдан хоригдож буй хоригдогч нь ихэнх тохиолдолд шалгагдаж

буй гэмт хэргийн ангилал, зүйчлэл, гэмт үйлдэл дэх өөрийнх нь оролцоо, гэмт үйлдлээ хэрэгжүүлсэн байдлаас шалтгаалсан сэтгэл зүйн хямралд орсон, цочирдмол шинжтэй цагдан хоригддог. Үүний дараа цагдан хорих байрны хуулинд заасан онцлог зохион байгуулалт буюу хорих өрөөний орчин, бусад дотоод журамд дасан зохицох шаардлага бий болдог. Хуулинд заасан тодорхой хязгаарлалт бүхий энэхүү орчинд сэтгэл зүйн тодорхой өөрчлөлт бүхий хоригдогчийн хувьд тодорхой өөрчлөлтөнд орж болзошгүй байдаг.

Мөн шүүхийн шийтгэх тогтоолоор заагдсан төрөл дэглэмийн онцлог орчинд ч аливаа ялтны дасан зохицоход тодорхой бэрхшээлүүд гардаг. Түүнчлэн хорих ангийн байршлын онцлог, үйлдвэрлэлийн чиглэл, хөдөлмөрлөх үйл ажиллагаанд хамрагдаж байгаа ялтныг энэхүү онцлогт дасан зохицоход ч зайлшгүй анхаарах шаардлагатай.

Харуул хамгаалалт, албан хаагч ялтны хоорондын харилцаанаас шалтгаалан хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүрдэг. Үүнд хүргэдэг шалтгаанаас дурдвал:

1. **Албан хаагч ялтны хоорондын харилцааны хэм хэмжээ алдагдаж хэт лотносох.** Тухайлбал: 199..онд чанга дэглэмтэй ...дугаар хорих ангиас хоригдол О, Ц, Э, Б нарын тэргүүтэй 8 ялтан бүлэглэн зоонд архи ууж, харуул хамгаалалтын албан хаагчдад хутга мэс хэрэглэн айлган сүрдүүлж хүлж орхиод оргон зайлсан.

2. **Албан хаагчаас байгууллагын үйл ажиллагааны талаар ялтнуудад буруу ойлголт өгөх.** /Хорих ангийн албаны хурал тарсны дараа албан хаагчид ялтны амьдралын бүсэд орж ялтнуудад албаны үйл

ажиллагааны талаар буруу ташаа мэдээлэл өгөх/Тухайлбал: 20.. онд хорих ..-р ангийн хамгаалалтын ажилтанонцгой дэглэмтэй ялтнуудыг өршөөлд хамруулахгүй талаар ярьсан нь ялтнууд суулт зохион байгуулах шалтгаан болсон

3. Албан хаагчид ялтнаар албан ажлаа болон хувийн эд зүйл хийлгэдэг

/Ялтнуудаар хоол хийлгэх, гэр орондоо ажил хийлгэх, цахилгаан, станц, камер янзлуулах/ Тухайлбал: 200.. онд ..-р ангийн ялтан Ш ээлжийн дарга А.-гийн ээлж болгон дээр ээлжийн бүрэлдэхүүнд кофе аягалж өгдөг байж байгаад нэг өдөр кофенд нь унтуулах эм хийж өгөн оргон зайлсан.

4. Ялтнуудын үзэх харах эрх хэт нээлттэй болсон. Гадаад орны хорих байгууллагад бослого гарсан, шоронгийн талаарх кино үзэх зэргээс санаа, сэдэв авах/ Ялтны эрхийг хэт их анхаарах болж тэднийг бие бялдарын хувьд хөгжих, чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх нэрийдлээр бодьбилдингийн хэрэгсэл, биллярд, теннисний ширээ зэргийг амьдралын бүсэд байлгах болсон нь нөлөө бүхий этгээдүүдийн мөрийтэй тоглох боломж бүрдэж түүнээс болж гэмт хэрэг гарах нөхцөл бүрдэж эхэлсэн.

5. Харуул хамгаалалтанд ашигладаг цоож, хаалга, цонх, решотик төмрийн бэхлэгээ,хаалга нугас янзлуулах , түлхүүр тааруулж онгойлгох зэргээр харуул хамгаалалтын аюулгүй байдлыг хангуулах хэрэгсэлээ янзлуулдаг

Тухайлбал:Авдрант дахь онцгой дэглэмтэй хорих ангийн ээлжийн дарга ялтан Л-ээр сейфний түлхүүр тааруулж хийлгүүлэхэд ялтан Л. түлхүүрийг хувиан авч тухайн ээлжин дээр халдлага зохион байгуулж сейфнээс буу авч ялтан Т, Ч, нартай хамтран тус ангид ял эдэлж байсан Ц, Б, Ч нарыг хүчиндэн хоригдож байсан өрөөнд нь

алж орхиод, харуулын 2 ахлагчийг лантуугаар цохиж алан, 1 ахлагчийг үхлүүт орхиод зэвсэглэж сувилагч М-ийг барьцаалан оргон зайлсан зэрэг ноцтой хэргүүд гарч байсан байна.

6. Ялтнуудаар харуул хамгаалалтын техник, барилга, үндсэн болон туслах хашаа барилддаг /Тухайн ялтан хамгаалалтын хашааны бат бөх чанар, түүнийг алдагдуулах боломжийг бүрдүүлдэг/ Тухайлбал: 20.. онд насанд хүрээгүйчүүдийн хорих ангиас ялтнууд хамгаалалтын хэрмэн хашааг цөмлөн бүлэглэн оргосон.

7. Гэмт хэрэг үйлдэх тохиромжтой байр, байршил, гэмт үйлдэлээ хэрэгжүүлэхэд боломжтой ажилдаа хайнга, сул албан хаагчдыг судлах, дотносох, тэдний итгэлийг олох, өөрсдийн эрхшээлдээ оруулахаар монго тогрог эд зүйлээр татах гэх мэт

Хоригдогч, ялтны дундаас албан хаагчийн үүрэг гүйцэтгэлт, улмаар албаны үйл ажиллагаанд нөлөөлөхийг оролдох, өөртөө ашигтай шийдвэр гаргуулахыг эрмэлзэх, албан хаагчийг янз бүрийн аргаар эрхшээлдээ оруулахыг хичээх, албан хаагчийн амь бие эрүүл мэндэд халдах гэх мэт хорих анги, баривчлах, цагдан хорих байрны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зорилго бүхий үйлдлийг байнгын буюу тасралтгүй шинжтэйгээр үйлдсээр байна. Түүнчлэн хоригдогсод нь хорих анги, баривчлах, цагдан хорих байранд бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдэх, хорих ангийн харуул хамгаалалтын сул байдал, албаны үйл ажиллагааны онцлог байдлыг ашиглан хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийг эвдэх, зориулалтын саад, төхөөрөмжийг давж туулах замаар ганцаар

болон бүлэглэн оргох гэмт хэрэг үйлдсээр байна.

Оргох гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг шалтгаан нөхцөлд:

Алба, ажилтны зүгээс

1. Албан хаагчдын эрх мэдлээ буруу ашигладаг, харьцааны доголдол
2. Албан хаагчдын дарамт, шахалт
3. Албандаа хайнга хандаж ажлын хариуцлага, сонор сэрэмж алдсан
4. Харуул хамгаалалтын хүн хүч, техник хэрэгслийн буруу зохион байгуулалт

Ялтны зүгээс

1. Ялтнуудын хоорондын харилцаа
2. Ялтны дундах гал хам, бүлэглэлийн дарамт шахалт
3. Ар гэрийн амьдрал түүнд тулгарч буй бэршээл
4. Хувь хүний өөрийн зан чанар, ял эдлэх үеийн сэтгэл санаа
5. Хорих анги, цагдан хорих байрны орчин нөхцөлд дасан зохицож чаддаггүй
6. Ажлын ачаалал /шантрах/
7. Нуугдмал гэмт хэрэг нөхөн илрэх тохиолдолд
8. Өш хонзон санаж оргох /албан хаагчдад/
9. Ял эдлэх орчин, байгаль цаг уурын өөрчлөлт, сэтгэл санааны тогтворгүй байдал, тохиолдолын нөхцөл байдлаас болж оргох гэх мэт олон хүчин зүйл нөлөөлдөг.

Хорих байгууллагын удирдлага болон харуул хамгаалалтын албадаас дараах хэд хэдэн чухал зорилтыг шийдвэрлэх шаардлагатай.

Иймд дараах урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай байна.

1. Хорих анги дахь амиа хорлох, бусдыг барьцаанд авах, оргох, албан хаагчдын хууль ёсны шаардлага эсэргүүцэх, суулт, өлсгөлөн зарлах явдалд нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг шуурхай илрүүлж, улмаар арилгах
2. Хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад орчны болон бие хүнд гарах сэтгэл зүйн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх
3. Онцгой нөхцөл байдлын үед ажиллах төлөвлөгөөг боловсронгуй болгож, үйл ажиллагаандаа дадал хэвшил болгон мөрдөн ажиллах
4. Хорих ангийн дотоод албадын болон бусад олон нийтийн байгууллагатай ажлын хоорондын уялдаа холбоог сайжруулах, мөн сэтгэл зүйч, нийгмийн ажлын мэргэшлийн түвшинг дээшлүүлэх шат дараалсан арга хэмжээг тогтвортой хэрэгжүүлэх
5. Ялтны уур амьсгалыг судлан түүнийг гүйцэтгэх ажлын шугамаар болон харуул хамгаалалтын хяналтанд авах, онцгой анхаарал татсан этгээдүүдийн талаар судалгаа, бүртгэл хөтлөн хяналтыг сайжруулах
6. Урьдчилан сэргийлэх болон албаны өдөр тутмын үйл ажиллагааны уяалдаа холбоог нэгтгэн дүгнэх зэрэг болно.